

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

№ 20/01


Улаанбаатар хот

Компанийн 2019 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дахь заалт, 96 дугаар зүйлийн 96.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 9.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлаас гарсан дүгнэлт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Эрнст энд Янг Монголиа Аудит” ХХК-ийн гаргасан 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Компанийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хангалттай гэж дүгнэсүгэй.
3. Энэхүү тогтоолын 2-т заасан тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж зохих шийдвэрийг гаргуулахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга /Б.Дэлгэржаргал/-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн Аудитын хороо /Ж.Жаргалсүрэн/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



Б.ДЭЛГЭРЖАРГАЛ



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

№ 20/02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 46 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 23 дугаар зүйл, Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.8.8 дахь заалт, Ногдол ашгийн бодлогын 2.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2019 оны жилийн эцсийн цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 1.50 (нэг төгрөг тавин мөнгө) төгрөгөөр тогтоож, 2019 оны цэвэр ашгаас 24.44% буюу 1,200,000,000 (нэг тэрбум хоёр зуун сая) төгрөгийг мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2020 оны 4 дүгээр сарын 30-ны дотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль, тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

№ 20/03


Улаанбаатар хот

**Компанийн 2020 оны үйл ажиллагааны
төлөвлөгөө, төсөв батлах тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 9.6.1 дэх заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны төсвийг энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсугай.
3. Компанийн үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө, төсвийн зорилтыг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:


Б.ДЭЛГЭРЖАРГАЛ



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

№ 20/04


Улаанбаатар хот

Компанийн 2020 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг батлах тухай

“ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.5 дахь заалт, Компанийн Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын 6.8, 6.12 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлаас гарсан дүгнэлт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 02 сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны эх үүсвэрийн төлөвлөгөөг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Компанийн 2020 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнд өрийн бичиг гаргах, хөрөнгө итгэмжлэн удирдах, бусад арилжааны эх үүсвэр татах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.
3. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Компанийн 2020 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд заасан хэмжээ, нөхцөлийн хүрээнээс давсан болон хоёрдогч эх үүсвэрийн санал, Компанийн тухай хуулийн дагуу тогтоосон их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг хууль тогтоомжид заасан журмын дагуу Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсны үндсэн дээр байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.
4. Компанийн 2020 оны эх үүсвэрийн төлөвлөгөөний гүйцэтгэл, татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнаж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:


Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

No 20/05

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захирлын 2019 оны
гүйцэтгэлийн үр дүнг батлах тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 81 дугаар зүйлийн 81.5.4 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 9.6.9 дэх заалт, Компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан Хөдөлмөрийн контракт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн дүгнэлт, санал, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Гүйцэтгэх захирал О.Болдбаатарын 2019 оны гүйцэтгэл, түүний үр дүнг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар, түүнд олгох 2019 оны үр дүнгийн урамшууллыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

№ 20/06

Улаанбаатар хот

**Хоёрдогч өглөгөөр өөрийн хөрөнгийг
нэмэгдүүлэх санал оруулах тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журмын 5.2.1, 5.2.2 дахь заалт, Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын 3 дугаар бүлгийн 3.3, 3.5 дахь заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэхэд шаардлагатай өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 5,000,000,000 (таван тэрбум) хүртэл төгрөгийн хоёрдогч өглөгөөр нэмэгдүүлэх саналыг Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хуралд шийдвэрлүүлэхээр санал оруулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан хэмжээний хүрээнд холбогдох хууль, тогтоомжийн дагуу Хоёрдогч өглөгийн нөхцөлийг тогтоох, гэрээ байгуулах шийдвэр гаргах эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд олгох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны ээлжит хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

№ 20/07

Улаанбаатар хот

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх
зөвшөөрөл олгох тухай**

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”)-ийн дүрмийн 9.6.20, 20.1, 20.5 дахь заалт болон Компанийн Гүйцэтгэх удирдлагын зүгээс танилцуулсан саналыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:


1. “Анд Системс” ХХК-тай Менежментийн үйлчилгээний гэрээг 1 жилийн хугацаатай байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. “Анд Системс” ХХК-тай байгуулах Менежментийн үйлчилгээний гэрээний хөлсийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолд заасан нөхцөлийн дагуу “Анд Системс” ХХК-тай холбогдох гэрээний нөхцөлийг хэлэлцэн тохирох, хэлцэл байгуулах, үйлчилгээний хөлсийг гэрээний нөхцөлийн дагуу төлөхийг Компанийн Гүйцэтгэх захирал /О.Болдбаатар/-д зөвшөөрсүгэй.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



/С.БОРГИЛ/

_____/Н.ЦЭВЭГМИД/



/Ж.ЖАРГАЛСҮРЭН/



/С.ЭНХ-АМГАЛАН/

_____/Ч.НОМИН/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 2 сарын 03-ны өдөр

№ 20/08

Улаанбаатар хот

“ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах санал оруулах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 62.1.1, “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 8.4.1 дэх хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрэмд дараах агуулгатай өөрчлөлт оруулах саналыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, шийдвэрлүүлэхээр тогтсугай.

Өөрчлөлт оруулахаас өмнөх	Өөрчлөлт оруулсны дараах
8.4.12.ТУЗ-өөс боловсруулсан компанийн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэн батлах;	8.4.12.ТУЗ-өөс боловсруулсан компанийн жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайланг хэлэлцэн батлах; /Энэ заалтыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр хүчингүй болсонд тооцов/.
8.5.7. Хувьцааг нэгтгэх буюу хуваах;	8.5.7. Хувьцааг нэгтгэх буюу хуваах; /Энэ заалтыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр хүчингүй болсонд тооцов/.
8.11. Компанийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй.	8.11.Хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг төлөөлөн удирдах зөвлөл хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай шийдвэр гаргах үед тогтоох бөгөөд энэ өдөр нь хурал хуралдуулах тухай шийдвэр гарсан өдрөөс өмнө байж болохгүй. /Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр өөрчлөв/.
9.6.11. компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах;	9.6.11.компанийн салбар болон төлөөлөгчийн газрыг байгуулах, хөрөнгө оруулалт хийх замаар компани үүсгэн байгуулах, хууль болон нийтээр дагаж мөрдөх журамд заасан хүрээнд бусад хуулийн этгээдийн хувь эзэмшлийг худалдан авах, компанийг төлөөлж үүсгэн байгуулагч, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх этгээдийг томилох, бүрэн эрхийг нь тодорхойлох;

	<i>/Энэ заалтыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр өөрчлөв/.</i>
9.7. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.	9.7. ТУЗ нь хууль тогтоомжид зөвхөн ТУЗ хэрэгжүүлэхээр зааснаас бусад бүрэн эрхээ Гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээний хүрээнд хариуцуулан гүйцэтгүүлж болно. <i>/Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр өөрчлөв/.</i>
14.6.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;	14.6.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд улируулан эсхүл шинээр сонгуулахаар нэр дэвшүүлэх; <i>/Энэ заалтыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр өөрчлөв/.</i>
19.2. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн саналын эрхтэй гишүүд санал нэгтгэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.	19.2. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн хуралд оролцсон саналын эрхтэй, сонирхлын зөрчилгүй гишүүд 100 хувь санал нэгтгэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. <i>/Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр өөрчлөв/.</i>
20.6. Сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана:	20.6. Компани нь дараах тохиолдолд Сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана: <i>Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр өөрчлөв/.</i>
22.2.Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.	22.2.Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу эргүүлэн худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана. <i>/Энэ заалтыг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр өөрчлөв/.</i>

22.3.Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болно.	22.3.Компани нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь худалдан авч болно. /Энэ хэсгийг “ЛэндМН ББСБ” ХК-ийн 2020 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ... дүгээр/дугаар шийдвэрээр хүчингүй болгов/.
--	---

2. Дүрмийн өөрчлөлтийн төслийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад тусгаж, батлуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

[Signature]
Б.ДЭЛГЭРЖАРГАЛ